

2025 оны 4 сарын 03-ны өдөр

№ 2025/20

Улаанбаатар хот

Сонирхолын зөрчилтэй
хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1, 92.4 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн О.Одбаярт 160,000,000 (нэг зуун жаран сая) төгрөгийн худалдан авалтын зээлийг дараах нөхцөлөөр олгохыг зөвшөөрсүгэй.

Зээлийн хүү	20% /жилийн /
Зээлийн хугацаа	30 сар
Зээл олголтын шимтгэл	1%
Эргэн төлөх нөхцөл	Сар бүр үндсэн зээл, хүүгийн хамт
Зээлийн зориулалт	Моннис Моторс Интернэшнл ХХК-иас Infiniti, QX80 маркийн автомашин худалдан авах

2. Зээлийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулан JN8AZ3DBXS9400514 тоот арлын дугаартай, Infiniti, QX80 маркийн автомашиныг Ард Кредит ББСБ ХК-ийн өмчлөлд шилжүүлэн фидуцийн гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулан зээлийн гэрээ болон фидуийн гэрээ байгуулах, компанийг төлөөлж холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар), зээл олголтыг хийх эрхийг Санхүү эрхэлсэн захирал (Ч.Гэндэнпил) нарт тус тус олгосугай.

4. Энэхүү санал хураалтад сонирхлын зөрчилгүй этгээдүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурдсугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ